

## 10

## ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ҮР ДҮН, СУРГАМЖ, ДУГНЭЛТ

### К.Аксолтан

1990-ээд он бол тус орны нийгэм эдийн засгийн амьдралд их эргэлтийн жилүүд байлаа. Хүн төрөлхтөний жам ёсны хөгжлийг дагаж Монгол улс 70 жил замнасан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас (ТТЭЗ) татгалзаж зах зээлийн эдийн засгийн (ЗЗЭЗ) замыг сонгож авлаа.

ЗЗЭЗ нь өөрийнхөө мөн чанараараа өмчийн олон хэлбэр түүний дотор ялангуяа хувийн өмчийн харилцааг үүсгэж хөгжүүлэхийг шаарддаг. Учир нь улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд хүмүүсийн хувийн ашиг сонирхол, хувийн санаачлагыг ашиглах, ардчилал, эрх чөлөөг жинхэнэ ёсоор баталгаажуулах эдийн засгийн баттай үндэс нь гагцхүү хувийн өмчийн нөхцөлд бүрэн хэрэгжих бололцоотой.

Манай нийгмийн өмнө тулгарсан энэхүү түүхэн бодит шаардлага нь 1991 онд "Төрийн өмчийг хувьчлах тухай" хууль гаргахад хүргэсэн юм. Энэ бол цар хүрээ, агуулгаараа маш том үйл явдал. Нэг ёсны нийгмийн тогтолцоонд гарсан шинэ хувьсгал.

Хувьчлал хийсэн арга зам амар хялбар байгаагүй. Энэ талаар, ялангуяа эрдэмтэд, эдийн засагчдын байр суурь янз бүр, тухайлбал, цочир түргэн эсвэл аядуу зөөлөн аргаар хийх, тэрч байтугай заримдаа бүр эсрэг хувилбаруудыг хүртэл санал болгож байв. Эцэст нь гарааны ижил нөхцөл бүрдүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр (ХОЭБ) үнэгүй хувьчлах замыг сонгож авсан билээ. Үүний дүнд өмч хувьчлалаар 1991-1995 онд 20 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, өмчийг (тэр үеийн ханшаар) цэнхэр, ягаан тасалбараар ард иргэдэд олгосон юм. 1995 онд Монголын нийт хүн амын 48 орчим хувь нь хувьцаа эзэмшигчид болжээ.

Одоогоос 10 жилийн өмнө эхэлж байсан энэ ажлын үр дүнг өнөөдрийн өндөрлөгөөс харвал: Мал аж ахуй (МАА), худалдаа, хүнсний үйлдвэр, барилга, барилгын үйлдвэр, (Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрээс бусад), тээвэр, ахуй үйлчилгээ, мал эмнэлгийн салбар 100 хувь хувьчлагдсан гэж үзэж болохоор хувийн аж ахуйн секторт шилжсэн байна. Орон сууцны

хувьчлал үндсэндээ дуусах тийшээ ойртож (90 гаруй хувьтай) байна. Одоогоор хувьчлагдаагүй салбарт гол төлөв Дэд бүтэц, уул уурхайн зарим объектууд багтаж байгаа бөгөөд эдгээрийг Засгийн Газрын 2001-2004 оны хувьчлалын программд өргөн хамруулахаар тусгаж байна.

Ийнхүү хувийн сектор нь манай эдийн засгийн бүтцэд голлох нөлөө бүхий хэвшил нэгэнт боллоо. 1997 оны байдлаар нийт үндсэн капиталын 31 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 65 хувь нь зөвхөн хувийн хэвшилд ногдох болжээ.

ЗЗЭЗ-т шилжиж буй орнууд дахь өмч хувьчлалыг асар өргөн хүрээтэй, олон тооны зөрчлийг өөртөө агуулсан нарийн төвөгтэй, зовиуртай үйл явц гэж эрдэмтэд үзэж байна. Үнэхээр ч хэл ам, хэрүүл уруул ихтэй, хүнд хэцүү ажил болох нь өнгөрсөн 10 жилийн түүхэн сургамжаас ажиглаж байна. Үүнээс үзвэл, өмч хувьчлалаас гарах аливаа үнэлэлт, дүгнэлт нь өвөрмөц зөрчилтэй эерэг, мөрөг хоёрдмол талтай байх нь аяндаа ойлгогдож байна.

### 1. Хувьчлалын гол үр дүн

Манай хүмүүсийн нэлээд нь хувьчлалыг одоогийн эдийн засгийн хямралын гол буруутан мэтээр ойлгож дүгнэдэг. Харамсалтай нь өмч хувьчлал, хямрал хоёр цаг хугацааны талаар давхацсан нь уналтын муу нэрийг түүн рүү түлхэх таатай аян шалтаг болсон. Хувьчлалыг ингэж муучилж мушгихын оронд Засгийн газар анхнаасаа түүний удирдлага, зохион байгуулалт, хяналтыг нэг гарт төвлөрүүлж зангидаагүйгээс янз бүрийн алдаа, гажуудалд хүргэлээ гэвэл илүү үндэстэй болох бизээ. Ингэхлээр хувьчлалын ололт, үр дүнд бодитой хандъяа гэвэл энэ бүхний зааг ялгааг нарийн тунгаан бодож ойлгох нь зүйтэй.

Онолын хувьд хувьчлалын үр дүнг түүний тавьсан зорилготой холбож үзэх ёстой. Мэдээж сонгодог ойлголтоор, хувьчлалын зорилгод олон зүйл хамаарах боловч тэдгээрийн дотроос хамгийн түгээмэл шалгуур нь үр ашиг, бүтээмж юм.

Өнөөдөр манай хувьчлалын зорилгыг дээрх шалгууруудаар шууд үнэлэх үү, үгүй юу гэдэг асуудал тавигдаж байна. Яагаад гэвэл хамгийн наад зах нь хувьчлалын зорилгыг одоо хоёр үе шатаар ангилан үзэж байна. Үүнд: Нэгдүгээр шат (1991-1994) буюу төрийн өмчийг ХОЭБ-ээр үнэгүй хувьчилж тараасан үе. Хоёрдугаар шатыг (1995 оноос хойш) бэлэн мөнгөний арилжааны (хувьцааны) буюу харьцангуй сонгодог арга хэлбэрээр хувьчлал хийж эхэлсэн үе гэж хуваан үзэж болох юм. Энэ бол манай хувьчлалын нэг өвөрмөц онцлог зүйл.

Анхан шатны хувьчлалын зорилго нь үр ашиг биш, хувийн өмчийн үндэс суурийг (секторыг) бүрдүүлэх асуудал байж гэдэг нь хожим тодорхой болсон. Энэ тухай ноён Б.Энэбиш Өмч хувьчлалын комиссын илтгэлд (1992-1996 он) нэг бус удаа цохон тэмдэглэж байсан билээ.

Ер нь хувийн секторыг бүрдүүлэхийн хувьд ганцхан манайх ч биш хуучин социализмд байгаад ЗЗЭЗ-т шилжилт хийж байсан ихэнх орнууд ийм шахуу хөтөлбөр дэвшүүлж байсан юм.

Нэгэнт бид хувьчлалын зорилгыг шатчилж үзэж байгаа болохоор тэдгээрийн үр дүн ч мөн дээрх чиглэлээр үнэлэгдэх нь зүйн хэрэг байх. Ер нь энэ асуудлыг хүмүүс янз бүрийн талаас нь (онол, практик, нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй г.м) мөн эерэг, сөрөг янз бүрээр үнэлж үзэж байгаа. Миний хувьд доорх үнэ цэнийг нь түүний гол үр дүн, ололт гэж дүгнэж байна. Үүнд:

- 1.1. Өмчийн харилцааны (ялангуяа хувийн өмчийн) хувьд ЗЗЭЗ-т шилжих үндэс суурийг баттай бий болголоо.
- 1.2. Үр өгөөжөөр хэдий дутагдалтай (харилцан адилгүй) ч гэсэн нийт үндэстний хэмжээнд авч үзвэл бүх иргэдийг ямар нэг хэмжээгээр өмчтөн болгож, ЗЗЭЗ-т шилжих асуудлын

хамгийн хүндийг нугалж чадсан. Ийм ч учраас 1995 оны хаврын чуулганаас өмч хувьчлалыг "...Монгол орныг зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд түүхэн алхам болов" гэж дүгнэсэн юм. Өмч хувьчлалын үр дүнд малчид малаа үнэгүй авлаа. Жижиг худалдаа, үйлчилгээнд ажиллагчдад ажлынх нь байрыг анхны үнээр, давуу эрхээр хөнгөлөлттэй өглөө. Дээр нь нэмж, хот суурин газар улсын байранд амьдрагчдад 400 гаруй тэрбум төгрөгийн үнэтэй орон сууцыг нь үнэгүй бэлэглэв. Одоо тариачид, хот суурины гэр хорооллынхныг жижиг эзэмшлийн (хэтдээ хувийн өмчийн) газартай болгох арга хэмжээ, шийдвэр гарах цагаа хүлээж байна. Энэ бүхнээс үзвэл өмч хувьчлалаас манай иргэд хэчнээн их зүйл хүртэж, үр шимийг амсч байгаа нь тодорхой байна.

- 1.3. Сүүлийн 30 жилд хүмүүс анх удаа өөрийн сонирхолын дагуу эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй, идэвх санаачлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлэв.
- 1.4. Төрөөс татаас авч аж ахуй эрхэлдэг урьдын уламжлалыг халж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж, аж ахуйнхаа хувь заяаг өөрсдөө өөрсдөө бие дааж хариуцдаг идэвхтэй аргад сургаж байна.
- 1.5. Зах зээлийн шилжилтийн хамгийн хүнд бэрхийг хагалж мөр гаргаснаараа Монгол орон зах зээлд шилжих чадвартай юм байна гэдгийг дотооддоо төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгт нээн харуулж чадсанаараа хожим тэд гар сунгахад том дэмжлэг, нөлөө үзүүлсэн гэж бодож байна.

Хэдий ийм ололттой сайн зүйлүүд байгаа боловч сонгодог хувьчлалын зорилго, хэрэгцээ шаардлага, үр өгөөжтэй харьцуулж үзвэл манай хувьчлал ард түмний хүсэн хүлээж байсан шиг тийм ч их өгөөж, унацтай болж чадаагүй гэдгийг хэлэх нь зүйтэй. Анхных, тэгэх тусмаа ийм өргөн цар хүрээтэй, нарийн төвөгтэй ажилд огт алдахгүй гэвэл худал болно биз. Өнөөдрийн үнэний шалгуураар дэнслэхэд магадгүй оносноосоо илүү алдсан ч юм шиг харагдаж болох юм. Гэхдээ үүнийг бүрэн үнэн зөвөөр үнэлэхэд цаг хугацаа хэрэгтэй, хувьчлал ч бүрэн дуусаагүй үргэлжилж байна.

### 2. ХОЭБ түүнд өгөх үнэлэлт

ХОЭБ нь манайд төрийн өмчийг тэнцүү гарааны нөхцлөөр хувьчлахад хэрэглэсэн анхны арга, хүн бүр төрийн өмчөөс 10 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг өмчлөх эрхийг баталгаажуулсан үнэт цаасны эрхтэй баримт бичиг. Энэ аргын давуу болон сул талыг одоо хүртэл эрдэмтэд, улс төрчид, ер нь олон түмэн эерэг, сөрөг янз бүрээр үнэлцгээж ирлээ.

Төрийн өмчийг үнэгүй тарааж өгөх нь дэлхийн улсуудын хувьчлалын түүхэн туршлагын үүднээс цоо шинэ үзэгдэл гэдэг нь маргаангүй. Үүнийг постсоциализмаас (ТТЭЗ-аас) ЗЗЭЗ-т шилжсэн Дорнод Европын цөөхөн хэдэн оронд (Польш, Чех, Словак, ОХУ зэрэг) анх удаа туршиж хэрэглэсэн.

Тэр үед манайд ч өмч хувьчлах оновчтой арга хэлбэрийг идэвхтэй эрэлхийлж байсан үе. Ингэх хэд хэдэн үндсэн шалтгаан байлаа. Үүнд:

**Нэгдүгээрт**, манай ард түмэн хөрөнгө мөнгөний хуримтлалгүй, орлого багатай учраас бэлэн мөнгөөр хувьчлал хийгээд үр дүн багатай гэдэг нь тодорхой байв.

**Хоёрдугаарт**, төрийн өмч нь ард түмний хүч хөдөлмөрийн оролцоотойгоор бүтсэн болохоор түүнээс бүх иргэд адил тэгш хувь хүртэх ёстой гэсэн сэтгэл зүйн давалгаа нийгэмд буй болсон байсан.

**Гуравдугаарт**, манай техник, технологи нь хоцрогдож, үр ашиг нь муудчихсан үйлдвэрүүдийг худалдаж хувьчилна гэдэг найдвартай арга хэмжээ биш байв.

**Дөрөвдүгээрт**, хүмүүсийн мөнгөн хуримтлалтай болохыг хүлээвэл хувьчлал, зах зээлд шилжих зорилгыг хэрэгжүүлэхэд дэндүү урт хугацаа шаардагдахаар байв. Цаг үеийнхээ эдгээр бодит нөхцөл байдлыг ажиглаж мэдэрсэн Засгийн Газар, тухайлбал, тэргүүн сайд асан

Да.Ганболдын багийнхан дээрх улсуудын, төрийн өмчийг үнэ төлбөргүй хувааж өгсөн аргыг манай хувьчлалын практикт ашиглах санааг анх сэдэж, түүнийг ХОЭБ гэж нэрлэсэн юм.

Хувьчлалын эл аргад сайн, муу үр дагаварын аль аль нь бий. Гол давуу тал нь:

**Нэгдүгээрт**, ард түмэн гартаа мөнгөгүй, хуримтлалгүй тохиолдолд төрийн өмчөөс хүн бүрт адил тэгш хувааж хүртээх боломж олгосон. Хэдийгээр төгс сайн арга биш ч гэсэн тухайн цаг үеийн нөхцөлд ХОЭБ-ийг сонгож авсан нь онолын хувьд зөв байсан гэж үзэж байна.

**Хоёрдугаарт**, ингэсний үр дүнд хувийн өмчийн харилцааны үндэс суурийг харьцангуй богино хугацаанд бүрдүүлж чадсан. Улс төрийн ямар нэг зөрчилдөөн, хямралд хүргээгүй. Ямар ч гэсэн Монгол улс зах зээлд шилжих чадвартай юм гэдгийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө харуулж чадсан. Энэ бүхэн манай хувьчлал (ялангуяа эхний шат) анхнаасаа эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн зорилго, шинжтэй байсныг илэрхийлдэг.

Гэвч хувьчлалын янз бүрийн алдаа гажуудлыг ХОЭБ-ийн дутагдал, сул талтай холбож үзсээр ирлээ. Үүнд:

**Нэгдүгээрт**, ХОЭБ, МАА, худалдаа, үйлчилгээ, тээвэр зэрэг жижиглэж хувьчлахад хялбар салбаруудад зохих сайн үр дүнгээ өгсөн боловч аж үйлдвэр, барилга, газар тариалан зэрэг технологийн нарийн уялдаатай, эргэлтийн хөрөнгө их шаарддаг томоохон салбаруудад тэр бүр тохиромжтой арга биш байжээ. Гэхдээ энүүнд ХОЭБ-ээс өөр зарим бодит шалтгаанууд давхар нөлөөлсөн гэдгийг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, үйлдвэрүүдийн техник, технологи хоцрогдсон, уламжлалт зах зээл, аж ахуйн нэгжүүдийн хэлхээ холбоо алдагдсан, өрсөлдөх чадваргүй, зардал ихтэй дээр нь өмнөх үеэс өвлөсөн банкны болон гадаад өр зээлтэй байсан нь тэдгээрийг тийнхүү хэвийн ажиллаж чадахгүйд хүргэсэн юм. Хэрэв улс, яг тэр мөчөөс хөнгөлөлттэй зээл, татаасаар тэтгэдэг хуучин уламжлалаа гэтэн зогсоосон бол хувьчилсан, хувьчлаагүй нь ялгаагүй мөн л тэгсхийгээд хямрах байсан. Үүнээс үндэслээд үйлдвэрүүдийн уналтыг ХОЭБ, түүний арга зүйн үндэстэй шууд холбож үзэх нь судалгаагаар батлагдахгүй байна. Харин ХОЭБ-ийг тохирох, тохирохгүй бүх салбар, аж ахуйн нэгжүүдэд хавтгайруулан хэрэглэсэн нь буруу болжээ гэвэл илүү оносон дүгнэлт болж магадгүй.

**Хоёрдугаарт**, томоохон үйлдвэр, аж ахуйн газруудын өмч хөрөнгө хэдэн мянгаас хэдэн арван мянган хувьцаа эзэмшигчдийн дунд хуваагдаж тарснаас болж өмч эзэнгүйдэж улам хүнийслээ. Энэ бол үнэхээр ХОЭБ-ийн дутагдалтай сул тал мөн. Тухайлбал, Монгол савхи, Говь зэрэг томоохон ХК-ны хувьцаа 38-78 мянга хүртэл эзэмшигчдэд хуваагдаж задарч байв. Энэ явдал зарим үйлдвэрийн газруудын удирдлага хариуцлага, дотоод хяналтыг сулруулж, өмч хөрөнгө үрэгдэж алдагдах, дундаас нь хууль бусаар идэж завших зэрэг маш олон сөрөг үр дагаварыг авч ирсэн гэж ард олон бухимддаг. Эцэст нь өмч эзэнгүйдэж, хувьчилж өгсөн, авсны алинд ч наалдсан юмгүй хоосон хонгил болон хувирсан үйлдвэрүүд олон гарлаа.

**Гуравдугаарт**, нэгэнт хувьчлах бүх объектийн эдийн засгийн нөхцөл ижил биш тохиолдолд ХОЭБ-ээр гарааны адил тэнцүү нөхцөл бүрдүүлэх нь зөвхөн онолын хувьд бололцоотой болохоос түүнийг жинхэнэ практик амьдрал дээр бодитой хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь анхнаасаа мэдрэгдэж байсан зүйл юм. Өөрөөр хэлбэл, гарааны адил тэгш нөхцөл гэдэг нь харьцангуй ойлголт байсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

### 3. Өмч хувьчлах гол дутагдал

Хувьчлалын дутагдал гэдэг ойлголт түүнийг хэрэгжүүлэх явцад гарсан алдаа, гажуудлаас ялгаатай. Тэгэхлээр энд бүх дутагдал, гажуудлын талаар ярихгүй, харин зөвхөн сонгодог хувьчлалын агуулгатай харьцуулахад манай хувьчлалын үр дүнгийн үндсэн дутагдал чухам юу байж вэ гэдэг талаас нь авч үзэж байгаа юм. Энэ үүднээс манай хувьчлалын гол дутагдлыг доорхи байдлаар дүгнэн үзэж байна. Үүнд:

3.1. Манай хувьчлал дэлхийн улс орнуудын (түүний дотор Дорнод Европын) хувьчлалын нийтлэг зорилтоос (үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдал, улсын өрийг

багасгах г.м) нэлээд ялгаатай, өр нь цочир түргэн хувьчлахыг хичээж хэлбэр (хувийн өмчийн) талыг нэлээд барьсан байна.

3.2. Хувьчлалын эцсийн (туйлын) зорилго нь тухайн аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлж, үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэхэд шууд чиглэх ёстой. Гэтэл өнөөдөр тэгтлээ хөгжиж өөрчлөгдсөн үйлдвэрийн газрууд хэр олон билээ. Өөрөөр хэлбэл, одоогийн хувьчлагдсан ихэнх аж ахуйн нэгжүүд зардал хэмнэж, үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэлдэг жинхэнэ сонгодог зарчимд одоо хүртэл төлөвшиж орсонгүй.

3.3. Монополийг задалж арилгах нь хувьчлалын нэг гол зорилт байх ёстой. Гэтэл хуучин төрийн өмч гэгдэж байсан үйлдвэрүүдийн монополийг эрх одоо хэсэг, бүлэг хүмүүсийн хувийн монопольд шилжсэн нь манай хувьчлалын бас нэг зарчмын дутагдал. Үүнээс үндэслээд хувьчлалын амин сүнс гэгддэг өрсөлдөөнийг хөгжүүлэх гол шаардлага хангагдсангүй. Тэгэхлээр, өрсөлдөөнгүй, үр ашиг муутай, төрийнхийг хувийн монополиор сольсон ийм өрөөсгөл хувьчлалыг сонгодог хувьчлалтай яаж зүйрлэж үзэх вэ.

3.4. Зах зээлийн хуулиар хувьчлагдсаны дараа үйлдвэрлэл эрчимжиж, тэр хэмжээгээр ажиллагчид түрэгдэж шахагдаж байдаг жамтай. Гэтэл манай хувьчлалын явцад ийм дэвшилтэд өөрчлөлт явагдаагүйгээр барахгүй, харин түүний оронд үйлдвэрүүдийн сул зогсолтоос үүдсэн ажилгүйдлийн тоо эрс нэмэгдлээ. Үйлдвэр, аж ахуйн газруудад ХОЭБ-ээ (хувьцаагаа) оруулж өмчтөн болсон хэрнээ эзэмшигчид нь түүнийхээ ач холбогдол, үүрэг, хариуцлагыг удтал ойлгохгүй явж ирлээ. Энэ бол өмч эзэндээ хүрэхгүй, хүнийссэний шинж гэж үзэхээс өөр яахав. Бидний дээрх дурдсан дутагдалд хувьчлалын арга, арга зүйн үндэс зохих хамааралтайгаас гадна төрийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагаатай бас нэлээд холбоотой гэж үзэж байна.

### 4. Хувьчлалын арга, тактик, үйл ажиллагааны алдаа гажуудал

Хувьчлалын арга, тактик, үйл ажиллагаа тун их алдаа, согогтой болсон. Хувьчлал бол зах зээлийн үед аливаа улс орны зайлшгүй дамжих ёстой зүй тогтолт үйл явц. Тиймд хувьчлах чиг шугам, явуулсан цаг хугацааг бид бүрэн дэмждэг. Ингэхлээр хувьчилсан нь алдаа биш, харин түүний аргачлал, арга зүйг боловсруулах, үйл явцыг нь удирдаж зохион байгуулахдаа алдаа гажуудал гаргасан юм. Хувьчилна гэдэг хэлбэрийн асуудал биш. Энэ нь улс орны хөгжлийн хувь заяатай холбоотой, маш хариуцлагатай ажил. Уг нь онолын үүднээс хувьчлалыг буруу хийж алдах эрх хэнд ч байхгүй. Гэхдээ ажлын арга туршлага, мэдлэг чадвар, зохион байгуулалт дутвал алдахгүй байх баталгааг хэн ч өгч чадахгүй билээ.

Энд хувьчлалын явцад гарсан элдэв гажуудал, зөрчил бэрхшээл, тэдгээрийн шалтгаан болгоныг нэг бүрчлэн дурдахгүй, зөвхөн арга, тактик, удирдлага, зохион байгуулалтын шинжтэй зарим нэг үндсэн алдаа гажуудлыг л авч үзэх гэж байна.

Тэгвэл өмч хувьчлал чухам хаанаа алдаж гажуудсан юм бэ гэвэл:

4.1. Анх сонгож авсан арга хэлбэр (ХОЭБ), түүний арга зүйн зарчим дээр байна. Учир нь ХОЭБ бол бүх юмыг ганцхан аргад (загварт) захируулж, хувьчлалын бусад олон арга хэлбэрийг (шууд худалдах, зээлээр олгох, түрээслэх, хамт олонд нь үнэгүй, эсвэл хямдруулж өгөх, задлан худалдах, нэмэлт хөрөнгө оруулах г.м) хослон хэрэглэх бүтээлч хандлага, аливаа санаачлагыг боогдуулсан, энэ арга барил одоо ч гэсэн үргэлжилж байна.

4.2. Өмч хувьчлал, Аж ахуйн нэгжийн тухай хуулиудын зарим зөрчилтэй, хоёрдмол утгатай заалт (2, 17, 21 дүгээр зүйлүүд дэх) шийдвэрүүдэд байсан. Хуулиудын эдгээр цоорхойг орон нутаг, аж ахуйн удирдлагууд өөрсдийн хууль зөрчсөн үйл ажиллагаанд овжин ашиглаж, хуулийг чанд биелүүлэхгүй гажуудуулж байсан нь түүхэн баримт.

4.3. Төрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, хяналт, түүний арга механизмын дутагдалтай холбоотой байв. Төрийн өмч хөрөнгийн (нэгдэл ороод) бүртгэл, зарцуулалт, хадгалалт

хамгаалалтанд тавих төр, олон нийтийн хяналт сүрхий алдагдсан. Өөрөөр хэлбэл, өмч хувьчлалыг хяналтгүй сул орхисон. Энэ нь ялангуяа аж ахуйн удирдагчдад хууль журам зөрчих, төрийн өмчөөс завших, элдэв зөрчил, гажуудлыг хяналтаас гадуур чөлөөтэй үйлдэх боломж олгосон нь хувьчлалын нэр хүнд, тэгш, шударга байх зарчимд цохилт өгсөн ноцтой алдаа болсон.

4.4. Өмч хувьчлал нь эдийн засгийн гэхээсээ улс төрийн (ялангуяа гадаад) зорилгод илүүтэй чиглэгдсэн бөгөөд манайх шиг оронд ХОЭБ дангаараа үр ашигтай хувьчлал хийхэд тохирох эсэхэд бодитой сонголт (үнэлэлт) хийгээгүй, тэрч байтугай хувьчлалд ерөөсөө сэтгэл зүйн бэлтгэлгүй орсон.

4.5. Хэрэв аргыг нь зөв олж зохион байгуулсан бол харьцангуй богино хугацаанд үр ашигтай хувьчлал хийх бололцоотой салбарын нэг нь ХАА ялангуяа МАА байсан юм. Гэтэл ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн хөдөө аж ахуйн нэгдлийн (ХААН) өмчийг хувьчлах арга хэлбэрийг "Нэгдлийн гишүүд, малчид өөрсдөө мэднэ" гэж хэлээд (дараа нь өмч хувьчлах хуулинд яг энэ нэр томъёоллоор орсон) будлиулчихсан. Уул нь мал, малчдаа сайн мэддэг хүмүүсийн өөрсдөөр нь шийдвэрлүүлбэл илүү зөв болно гэж бодсон хэрэг. Гэтэл амьдрал дээр бодсоноор болсонгүй. Малчдад олгосон эрх, үнэн чанартаа нэгдлийн дарга нарын хувийн үзэмж, эрх дархын асуудал болж гажив. Хувьчлалыг доороос малчдаар хийлгэх гэсэн ерөнхий сайдын санаа ингэж алдаа болж хувирсан юм. Гэхдээ бүх салбарын хувьчлалаас арай дөнгүүр нь МАА-нх боллоо.

4.6. "Нэгдлийн гишүүд, малчид мэднэ" гэсэн дээрх үгээр халхавчилж тухайн үед хувийн өмчтөн, хувьчлалыг хамгийн идэвхтэй эсэргүүцэж байсан хүчин болох ХААНХДЗөвлөл буюу түүний 8 дугаар их хуралд ХАА-г хувьчлах удирдамжийг боловсруулах эрхийг олгосон. Өмч хувьчлах тухай хуулийн цоорхой, дээрх удирдамжийн алдаанаас болоод тус салбарын хувьчлалын хамаг гажуудал, чирэгдэл, хүнд суртлын эх булаг ундарсан. ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай асар их үндсэн хөрөнгө (хашаа, худаг, машин техник, байшин барилга, өндөр ашиг шимийн мал зэрэг) үрэгдэж алга болсныг өмч хувьчлалын ээдрх бодлогын алдаа, үйл ажиллагааны дутагдалтай холбож үзэхээс өөр аргагүй юм. ХААН-ийг заавал ХК-аар дамжуулж хувьчлах шийдвэрийг хүчлэн гаргуулагчийн хувьд дээрх алдаа гажуудлын хариуцлагыг хэт хуучинсаг хүчин түүний дотор ХААНХДЗ-ийн удирдлага хуваалцах ёстой.

4.7. Машинт аж үйлдвэрийн том фабрик, завод, нүүдлийн бэлчээрийн МАА хоёрыг хувьчлахад адилхан аргачлал, арга зүйгээр хандсан нь бүдүүлэг алдаа болсон. МАА-г хувьчлахад ХОЭБ-ийг их, бага гэж хуваасан нь эцэстээ ямар ч утга агуулгагүй болохыг амьдрал өөрөө заслаа. Хоёрдмол эзэнгүй болгохын тулд ХААН-ийн өмчийг бүрэн задлах ёстой гэдгийг хууль, удирдамж боловсруулагчдын хэн нь ч ойлгосонгүй. Арга зүй, тактикийн шинжтэй ийм чухал асуудлуудыг тухайн үед үүнийг зохион байгуулж байсан төрийн байгууллагуудын аль нь ч анзааралгүй өнгөрөөсөн юм.

4.8. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийг нээж, компанийн жинхэнэ эздийн удирдлагын бүтцийг бүрдүүлэх явдал дээр нэлээд цаг алдсан нь бас зохих нэрмээс болсон гэж бодож байна.

Хувьчлалын явц гүнзгийрч удах тусам хүмүүс түүнээс үр дүн нэхэж, шаардлага тавих нь зүй ёсны хэрэг. Тухайлбал, доктор, профессор Г.Пүрэвбаатар "Баянхангай" концерний ерөнхийлөгч Ю.Дашбал нар хувьчлалын ашиг тусад маш их сэтгэл гонсгор байгаагаа илэрхийлээд, энэ арга хэмжээг зогсоох, тэр ч байтугай дахин цоо шинээр хийх тухай асуудлыг хүртэл хэвлэлээр дамжуулан тавьж байсан удаатай. Ер нь судлаачийн хувьд ажиглахад манай хувьчлал гол нь өмч тараасан, үр ашиг муутай, өмч эзэндээ ойртоогүй (ялангуяа үйлдвэр, барилгын салбарт) хэлбэр хөөцөлдсөн өрөөсгөл шинжтэй болсон нь үнэн билээ. Тухайлбал, малыг малчдад шууд өгөх гэж яаж буруутаж, будлиантсаныг та бүхэн санаж байгаа. Дараа нь маш олон жижиг, хувьцаа эзэмшигчдэд тараасан үйлдвэрийн газруудын өмчийн хувь заяа ямар хүнд хэцүү байлаа.

Үүнээс гадна ӨХК-ынхноос авахуулаад манай зарим хүмүүс энэ бол хувьчлалын эхний үе шатанд байх зүй ёсны үзэгдэл, түүнийг дараачийн шатанд (үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үед) цэгцэлж засчихаж болдог гэсэн үзэл бодолтой байсныг хэлэх нь зүйтэй. Эхний шүүмжилдэг хүмүүсийн, хувьчлалыг гол нь эдийн засгийн (улс төрийн биш) зорилгын үүднээс үр ашигтай хийх ёстой гэж үзэж байгаа санаа нь уг нь зүйтэй боловч нэгэнт хожимдсон, дахин эргүүлэхээс өнгөрсөн зүйл байв. Харин хоёрдахь чиглэл баримтлагчдын үзэл бодлын хувьд хэлэхэд ҮЦЗЗ эхэлсээр 6 жилийн нүүрийг үзэж байгаа боловч одоогоор хувьчлалын үр дүн сайжирч, дээрдсэн юм ажиглагдахгүй байна.

#### 4. Хувьчлалын туршлага, онцлог ялгаа

**1. Туршлага.** Манай хувьчлалын үр дүн эцэстээ хэр амжилтанд хүрэх нь одоохондоо хараахан тодорхой болоогүй байна. Бага эдийн засагтай, буурай хөгжилтэй орны хувьд бидний зам цоо шинэ, урд өмнө үүгээр хэн ч явж байгаагүй болохоор хувьчлалын практикт нэгэн туршлага болон үлдэж болох юм. Үнэндээ ХОЭБ-ийг манайд Дорнод Европынхоос арай өөр нөхцөл, болзлоор авч хэрэглэснийг хэлэх нь зүйтэй.

Постсоциализмын орнуудаас манайх, төрийн өмчийн бүх салбарыг яаж богино хугацаанд түргэн хувьчилж болохын үлгэр дууриаллыг харуулсан, үүгээрээ ч гадаад орнууд, олон улсын хамтын нийгэмлэгүүдээс талархал хүлээсэн гэж хэлж болно. Мөн энэ үеэр улс төрийн харьцангуй тогтвортой байдлыг бүрдүүлж чадсаныг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энүүн дээр хувьчлалын туйлын зорилго нь ямарч үнэ цэнээр өмчийг төрийн гараас салгаж (ялангуяа аж үйлдвэрийг) хувийн өмч болгохдоо байгаа юу эсвэл жинхэнэ эзэнд нь хүргэж үр ашигтай, цаашид хөгжөөд явахаар агуулгын өөрчлөлт хийхдээ байсан уу гэдэг талаас дүгнэж үзвэл, хожим бусдад үлгэр болох жинхэнэ туршлага мөн эсэхийг цаг хугацаа харуулах бизээ.

**2. Онцлог ялгаа.** Энд дараах өвөрмөц ялгаа, онцлог шинжүүдийг хамааруулан үзэж байна. Үүнд:

- 4.2.1. Хууль, эрх зүйн актуудыг эс тооцвол хувийн хэвшлийг дэмжсэн эдийн засгийн тусгайлсан арга хэмжээ аваагүй байхад ялангуяа мал аж ахуйг богино хугацаанд хувийн өмчийн харилцаанд шилжүүлэв.
- 4.2.2. Гадаадад өр зээлийг төлөөгүй байхад үйлдвэрийн газруудыг хувьчлах ажил явагдсан.
- 4.2.3. Хувьчлалыг эхнээсээ харьцангуй богино хугацаанд цочир маягаар явуулсан
- 4.2.4. Социализмын үед нийгэмчлэгдсэн мал хөрөнгөөс өмчийн эздэд нь (залгамжлагчид) буцааж олгоогүй. Үүгээрээ Дорнод Европын орнууд тэр ч байтугай Хятадын шинэчлэлийн аргаас ч ялгаатай.
- 4.2.5. Явцуу хүрээнд туслах чанартайгаар хэрэглэсэн ганц хоёр аргыг (дуудлага худалдаа, зээлээр олгох, менежментийн г.м) эс тооцвол манай хувьчлалын томоохон үе шат болгонд сорчилж сонгосон ганц, ганц аргаар хувьчлал явуулж ирлээ. Тухайлбал, хувьчлалын эхний шатанд ХОЭБ-ээр, хоёр дахь шатанд битүүмжилсэн дуудлага худалдаагаар, одоо үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдэд тендерийн арга хэрэглэхээр бэлтгэж байна.

#### Дүгнэлт

1. 1995 онд УИХ-ын хаврын чуулганаас: "Хэдийгээр өмч хувьчлал бодит бэрхшээлтэй тулгарч, зарим гажуудал, дутагдалтай явагдсан ч Монгол орныг зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд түүхэн алхам болов" гэж дүгнэсэн юм. Энэ бол түүний улс төр, нийгэм эдийн засгийн ач холбогдолд өгсөн чухал дүгнэлт мөн.
2. Өмч хувьчлал бол зах зээлийн эдийн засагт шилжихэд социалист өмчийн харилцааг өөрчлөхийн тулд зайлшгүй авах ёстой арга хэмжээ байв.

3. Бүх нийтийн нэг өмчийн ноёрхол задарч өмчийн олон хэвшил тухайлбал, хувийн өмчийн харилцааны үндэс суурь баттай тавигдлаа.
4. Өмч хувьчлал нь хувийн өмчийн хэвшлийг бий болгох талаар тавьсан зорилгоо биелүүлсэн боловч сонгодог хувьчлалын агуулгатай харьцуулбал өрөөсгөл хувьчлал болсон.
5. ХОЭБ, тус оронд төрийн өмчийг үнэгүй хувьчилсан анхны арга. Энэ чанараараа ХОЭБ угаасаа эдийн засгийн гэхээсээ улс төрийн зорилгод илүүтэй зохицсон хэлбэр байжээ.
6. Бие даасан хувийн хэвшил үүссэнийг эс тооцвол хувьчлалын дүнд үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, чөлөөт өрсөлдөөн хөгжүүлж, монополийг задалсан үндэсний хэмжээний өөрчлөлт (дэвшил) бараг гарсангүй. Манай хувьчлагдсан үйлдвэрүүдийн олонх нь хөгжиж дэвшихийн оронд улам бүр унаж зогссон. Иймд үйлдвэрүүд хувьчлагдаж эрчимжсэний үр дүнд биш, харин тэдгээрийн ажилгүй сул зогсолтоос болж ажилгүйдэл эрс нэмэгдлээ.
7. Томоохон үйлдвэр аж ахуйн газруудыг олон арван мянган жижиг хувьцаа эзэмшигчдэд үнэгүй хувааж өмчлүүлэх нь нийгмийн өмчийн хуучин агуулгыг өөрчилж, өмчийг эзэнд нь бүрэн ойртуулж чаддаггүй юм байна гэдгийг манай сургамж харууллаа.
8. Төрийн өмчийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, хувьчлалд тавих төр, олон нийтийн хяналт бүрэн алдагдсан. Хуулийн цоорхой, хувьчлалын удирдамжийн алдаа, төрийн хяналт алдарснаас төрийн өмчийг маш олон хүн хууль бусаар идэж завшсан гэж ард олон бухимддаг. Өнөөдөр хувьчлалын ололт амжилтыг хэн ч үгүйсгэж чадахгүй ч гэсэн түүнийг олон түмэн ерөнхийдөө алдаа, гажуудал ихтэй болсон гэж дүгнэж байгаа юм.
9. Хэдийгээр ХОЭБ-ээр хувьчлах байлаа ч гэсэн түүнийг улс орны онцлог, салбаруудын өвөрмөц байдлыг харгалзан, нийгмийн сэтгэл зүйн түвшнийг зөв үнэлээд түүнд тохирсон уян хатан арга хэлбэрүүдийг оновчтой хослон хэрэгжүүлсэн бол хувьчлалын явц, үр дүнг одоогийнхоос илүү хурдацтай бас үр ашигтайгаар явуулж болох байсан.